

1. Инфляциас хохирч болох субъектуудыг дурдахдаа хамаарахгүй зүйл дурдсан бол аль нь вэ?

- а. Банкнаас зээл авсан ААН б. Төрийн албан хаагч в. Тэтгэвэрийнхэн
г. Банкинд хадгаламжтай хүмүүс д. Бэлэн мөнгөтэй хүн

2. Нэмэлт сургалтгүйгээр, өөр мэргэжил эзэмшихгүйгээр ажил олж чадахгүй байгаа үеийн ажилгүйдэл нь:

- А. Бүтцийн ажилгүйдэл В. Улирлын ажилгүйдэл
С. Завсрын ажилгүйдэл Д. Циклийн ажилгүйдэл Е. Аль нь ч биш

3. “үлээх”, “хөөрөгдөх” гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдэл аль нь вэ?

- а. индекс б. инфляци в. брокер г. дилер

4. Гүйлгээнд байх мөнгөний тоо хэмжээ нийт бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ буюу ДНБ-ний өсөлтийн хурдаас илүү хурдтай өссөнөөр их хэмжээний мөнгө харьцангуй бага хэмжээний бүтээгдэхүүнд ноогдох болж эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давж үнэ өсдөг инфляцийг ямар инфляци гэдэг вэ?

- а. Эрэлтийн инфляци б. Нийлүүлэлийн инфляци
в. зардлын инфляци г. Орлогын инфляци

5. Үйлдвэрлэлийн чухал нөөцүүдийн үнэ болон цалин өгцөм өсөхөд үнэ дагаад өсдөг инфляцийг ямар инфляци гэдэг вэ?

- а. Эрэлтийн инфляци б. Нийлүүлэлийн инфляци

в. зардлын инфляци

г. Орлогын инфляци

6. Хурдтай инфляцийн үед хэн хожиж болох вэ?

а. төрийн албан хаагчид

б. банкинд хадгаламжтай хүн

в. мөнгөө бэлнээр хадгалж байгаа хүн

г. банкнаас зээл авсан хүн

7. Инфляцийн эдийн засаг үзүүлэх сөрөг нөлөөллүүдээс илүүц зүйлийг олно уу?

а. ажилгүйдэл өснө

б. бүтээгдэхүүний үнэ өснө

в. хүн амын орлого буурна

г. зээлдүүлэгчдэд ашигтай байна.

8. Инфляцийн түвшинг ямар үзүүлэлтээр хэмжих вэ?

а. хэрэглээний үнийн индексээр

б. бүтээгдэхүүн үйлчилгээний үнээр

в. мөнгөний ханшаар

г. хүн амын эдийн засгийн чадавхиар

9. Инфляцийн хурд хоёр оронтой тоогоор илэрхийлэгдвэл юу гэж нэрлэдэг вэ?

а. хэвийн инфляци

б. мөлхөө инфляци

в. цогцоо инфляци

г. гипер инфляци

10. Шилжилтийн ажилгүйдэл бий болдог үндсэн шалтгааныг тэмдэглэнэ үү.

а. Хувь хүмүүс ажлын байраа солих хүсэл эрмэлзлэл

б. Байгаль, цаг агаар, уур амьсгалын нөлөөлөл

в. Улс орны хөдөлмөрийн хуваарьт гарсан өөрчлөлт

г. Эдийн засгийн харилцааны хямрал, тогтворгүй байдал